

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны
 2024 оны 02 сарын 23 өдрийн
 18 албан бичгийн хавсралт

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2024 ОНЫ
 2 ДУГААР САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хийгдэх ажил	Хүрэх үр дүн	Хугацаа	Биелэлт
1	Хугацаатай мэдээ, тайлан гаргах	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг	дараа сарын 02-ны дотор	2024 оны 2 дугаар сарын байдлаар 32,106.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 21,800.0 мянган төгрөгийг зарцуулж 10,306.0 мянган төгрөг тайлант хугацаанд зарцуулагдаагүй үлдсэн байна.
		Шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах	Дараа сарын 08-ны дотор	Тайлант хугацаанд оруулбал зохих 16 мэдээллийг хуулийн хугацаанд нь бүрэн оруулсан.
		Нийгмийн даатгалын тайлан гаргаж, хүргүүлэх	Дараа сарын 05-ны дотор	1-р сарын НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд илгээж, тайлагнасан.
2	2023 оны хяналт шалгалтын баримтаа архивлаж архивт хүлээлгэн өгөх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	2 сар	1. Байгууллагын 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг гарган батлуулсан. 2. 2023 оны 71 баримтыг архивын нэгж үүсгэсэн.
3	Баянтал сумын Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх	Сангийн үйл ажиллагаа сайжирна	2 сар	Баянтал сумын хоршоо хөгжүүлэх сангийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар 3 зөрчил илэрч илэрсэн зөрчлийн хүрээнд 1 албан шаардлага, 5 заалт бий зөвлөмж хүргүүллээ. Албан шаардлага, зөвлөмжийн хариу ирүүлэх хугацаа болоогүй.

4	Сум дундын ойн ангийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна.	2 сар	Сум дундын ойн ангийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалт 40 хувьтай үргэлжилж байна.
5	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдах	2 сар	Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 42 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 1 дүгээр сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдалд хяналт шалгалт хийсэн бөгөөд хуулийн хэрэгжилт 98.5 хувьтай байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 6.4 хувиар өссөн.
6	Мэдээллийн ил тод байдлыг хангах	Мэдээллийн ил тод байдал хангагдах	2 сар	Мэдээллийн ил тод байдлыг хангаж, ойлгомжтой байлгах үүднээс байгууллагын веб хуудас болон самбарт 6 мэдээ мэдээллийг байршуулсан. Байгууллагын facebook хуудас https://www.facebook.com/profile.php?id=100090091147081/ -аар 40 мэдээллийг иргэд олон нийтэд түгээж ажиллалаа.
7	Бусад ажил	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна.	2 сар	1. Аймгийн удирдах ажилчдын шуурхай зөвлөгөөний 2 удаагийн хурлаас өгсөн 8 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн. 2. 2024 оны 01 дүгээр сарын 24-31-ний өдөр Монгол бичгийн дунд шатны сургалтыг Ерөнхий боловсролын лаборатори 5-р сургуулийн Монгол бичгийн багш Э.Олонцэцэг зааж, амжилттай дүүргэлээ. Тус сургалтад Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Стандарт, хэмжил зүйн газар, Статистикийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны газар гэсэн 4 байгууллагын 20

			гаруй албан хаагчид хамрагдаж, сургалтын төгсгөлд сурч мэдсэн мэдлэгээ бататгах үүднээс "Төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, дунд шатны сургалтын монгол бичгийн олимпиад"-ыг зарласан. Тус олимпиадад: Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга Н.Алтанцэцэг "Тэргүүн байр" Стандарт, хэмжил зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Гантуяа "Дэд байр" Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дотоод аудитор Г.Насанжаргал, Т.Отгонтамир нар "Гутгаар байр" тус тус эзэлж амжилттай оролцлоо. 3. 17-р жарны "Хилэнт эх" хэмээх модон луу жилийн "Цагаан сар"-ын баярыг угтан байгууллагын ахмад настандаа хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардууллаа. 4. Монгол Улсын мэргэшсэн дотоод аудитор бэлтгэх сургалт 30 хоногийн онлайн сургалтанд 2 албан хаагч хамрагдаж байна.
--	--	--	--

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Дотоод аудитор:



Л.Эрдэнэчимэг